

**АГААР ЦЭВЭРШҮҮЛЭГЧ
+ ИОНЖУУЛАГЧ
+ ЧИЙГШҮҮЛЭГЧ
АЕ-480**

Ашиглалтын заавар



Энэхүү бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө, ашиглалтын заавартай сайтар танилцана уу.

АГУУЛГА

1. Техникийн үзүүлэлтүүд	3
2. Цэвэршүүлэгчийн онцлог	3
3. Бүтээгдэхүүний харагдах байдал ба бүтэц	5
4. Шүүлтүүрийг суурилуулах	6
5. Чийгшүүлэгчийг бэлтгэх	7
6. Ажиллагааны тодорхойлолтууд	8
7. Хэрхэн хэрэглэх	10
8. Анхаарах зүйлс	11
9. Хориглох зүйлс	12
10. Шаардлагатай зүйлс	14
11. Шүүлтүүр /тоос мэдрэгч/ ионжуулагчийн цэвэрлэгээ ба арчилгаа	15
12. Сав баглаа боодлын жагсаалт	17
13. Гэмтлийг тодорхойлох	18

1.ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бүтээгдэхүүний нэр	Агаар цэвэршүүлэгч
Модел №	АЕ-480
Тэжээл	АС 220V-240V
Хүчин чадал	85W
Дуу чимээ (бага)	≤24,0dB
Ионжуулагч	10 сая/см³
Цэвэршүүлэх агаарын хэмжээ	488 м³/цаг
Формалдегид агаарын цэвэршүүлэх хэмжээ	P4
Цэвэрлэх талбай	54-80 м²
Шүүлтүүр солих хугацаа	Шүүлтүүр #1 2жил, #2& #3 6 сар
Цэвэр жин	10,8кг
Бүтээгдэхүүний хэмжээс	400x230x620 мм
Цэвэршүүлэлтүүд	Урьдчилсан шүүлтүүр, хүйтэн каталист шүүлтүүр, идэвхжүүлсэн нүүрсэн шүүлтүүр, нян бактерийн эсрэг шүүлтүүр, ХЕПА шүүлтүүр, сөрөг цэнэгтэй ионжуулагч ялгаруулагч, хэт ягаан туяат ариутгалын гэрэл

2. ЦЭВЭРШҮҮЛЭГЧИЙН ОНЦЛОГ

■ Хөнгөн цагаан урьдчилсан шүүлтүүр

Үндсэн шүүлт нь шүүлтийн эхний хэсэгт байрлах хөнгөн цагаан шүүлтүүрээр хийгдэнэ. Энэ нь 5 болон түүнээс дээш микроноос том ширхэгт тоос, тоосонцор, гуужсан арьс үс, өд, хийсэж буй бүрдлүүд болон бусад бохирдуулагчийг шүүнэ. Олон дахин угааж, дахин хэрэглэж болно.

■ Хүйтэн каталист шүүлтүүр

1. Хүйтэн каталистийн каталист задалгаанд хэт ягаан туяаны гэрэл, нарны гэрэл, өндөр температур, даралт зэрэг зүйлс шаардлагагүй. Энгийн амьдрах орчинд өөрөө хувирахгүйгээр агаарын бохирдлыг цэвэршүүлэх нөлөөг үзүүлнэ.

2. Хүйтэн каталистин гол найрлага нь хүнс болон анагаахын бодис байдаг учир хоргүй, зэврэхгүй, шатамхай биш байдаг. Энгийн орчинд формальдегид, аммони, бензин, TVOC, водород сульфид болон бусад хорт хийг цэвэрлэдэг. Үр дүнд нь ус ба карбон диоксид үүснэ. Хоёрдогч бохирдол үүсгэхгүй. Эрүүл гэрт хэрэглэхэд тохиромжтой, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт бүтээгдэхүүн.
3. Цэвэршүүлэлтийн үеэр энэ нь өөрөө хувирч урвалд орж, алга болдоггүйгээрээ онцлог. Иймээс гадны нөлөөтэйгээр эвдрээгүй л бол таваас дээш жил ашигласан ч үр дүнтэй хэвээрээ байдаг.
- **Нян бактерийн эсрэг хөвөн даавуун шүүлтүүр**
Нян бактерийн эсрэг шүүлтүүр нь 5 микроны диаметртэй биетийг нарийвчлан шүүдэг. Нян бактерийн эсрэг бодистой тул шүүхийн зэрэгцээ агаар дахь нян бактерийг 99% дээш үр дүнтэйгээр устгана.
 - **Өндөр үр дүнтэй ХЕПА шүүлтүүр**
ХЕПА шүүлтүүр нь 0,3 микрон болон түүнээс том хэмжээтэй нян, утаа, тоосны хэсгүүдийг 99% дээш хувиар шүүх чадвартай. Олон үйлдэлтэй шүүлтүүрийн хамтаар энэ шүүлтүүр нь утааг шүүхийн зэрэгцээгээр 20 нанометрээс дээш хэмжээтэй бактер, хөгц, тоос, аллерги үүсгэгч болон бусад жижиг нянгуудыг шүүнэ. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тогтоосноор шувууны ханиад, вирусын гаралтай ханиад, Легионелла зэргийн вирус нь 20 нанометрээс том. ХЕПА шүүлтүүр эдгээрийг шүүх чадвартай.
 - **Хэт ягаан туяат ариутгалын гэрэл**
365 нм хэт ягаан туяаны гэрлээр төрөл бүрийн нян бактерийг устгаж ариутгана. Хэт ягаан туяаны бактери устгагч гэрэл нь агаар, гадаргуу, усан дахь ариутгагчаар өргөн хэрэглэгддэг. Энэ нь тодорхой хэмжээний ион үүсгэхээс гадна агаарыг цэвэршүүлж, хөгцөрсөн үнэрийг арилгана. Агаар болон гадаргуу дээр вирус тархахаас хамгаалахын зэрэгцээ цэвэршүүлдэг.
 - **Сөрөг цэнэгтэй ион ялгаруулагч**
Ионжуулагч нь сөрөг цэнэгтэй болгох гэж хүчилтөрөгчийг гадна давхарга дээр нэмсэн их хэмжээний ион агаарт цацна. Энэ нь агаар дахь хийсэж буй тоос, тоосонцор, нян бактер, утаа зэрэг эерэг цэнэгт жижиг биетүүдийг өөрт татаж цуглуулах онцгой чадвартай. Ингэж хөвж буй биетүүдийг унагаснаар хүмүүст саад учруулахгүйгээр агаар орчныг цэвэршүүлдэг. Эдгээр биетүүдийг энгийн механик төхөөрөмжөөр шүүх боломжгүй. Харин сөрөг цэнэгтэй ион нь эдгээр хорт бодисуудыг татах онцгой яадвартай. Биетүүдийн хэмжээ жижиг байх тусам баригдах нь илүү болдог. Тэдгээрийг устгах үр дүнтэй арга юм.


3. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАРАГДАХ БАЙДАЛ БА БҮТЭЦ




4. ШҮҮЛТҮҮРИЙГ СУУРИЛУУЛАХ

1. Шүүлтүүрийг гялгар уутнаас гаргаж авах


А. Нүүрэн талыг онгойлго.



В. Шүүлтүүрийг ав.




С. Шүүлтүүрийг тээвэрлэлтийн сав уутнаас гарга.




Д. Хэрэглэхээс өмнө шүүлтүүрийг уутнаас нь гаргасан эсэхийг шалгах.

2. Шүүлтүүрийг болон нүүрэн талыг суурилуулах


А. Тоосны шүүлтүүр 1 (Нян бактерийн эсрэг шүүлтүүр ба ХЕПА шүүлтүүр)-ийн дотор ба гадна тал нь ялгаатай. Анхаар: Бариултай тал нь гадагш харуулж хийгдэх ёстой.



В. Шингээх шүүлтүүр 2 (Хүйтэн каталист ба эсийн идэвхжүүлэлттэй нүүрсэн шүүлтүүр)-ийн дотор ба гадна тал нь ялгаатай. Анхаар: Бариултай тал нь гадагш харуулж хийгдэх ёстой.



С. Урд талын шүүлтүүр 2 (Урьдчилсан шүүлтүүр)-ийн дотор ба гадна тал нь ялгаатай. Анхаар: Бариултай тал нь гадагш харуулж хийгдэх ёстой.



Д. Нүүрэн талыг буцааж хийх




Е. Нүүрэн талыг хийгээгүй үед төхөөрөмж ажиллахгүй.

5. ЧИЙГШҮҮЛЭГЧИЙГ БЭЛТГЭХ

2. Цэвэршүүлэгчийн хажуу талаас усны савыг гаргаж авах




1. Чийгшүүлэх шүүлтүүрийг уутнаас гаргах



3. Чийгшүүлэх шүүлтүүрийг усны сав руу хийх




4. Ус хийх хэсгийн резинэнэн тагийг онгойлгох



5. Усны савны 80%-ийг дүүргэхээр ойролцоогоор 1 литр хүйтэн ус хийх



6. Ус хийсний дараа таглааг таглах



7. Савыг цэвэршүүлэгч рүү буцааж хийх



8. Энэхүү төхөөрөмж нь ууршуулах замаар чийгшүүлдэг. Хэрэв усны саванд ус хийвэл төхөөрөмж автоматаар ууршуулж эхэлнэ. Чийгшүүлэх нь салхины хурдаас хамааралтай бөгөөд тиөхөөрөмжийн ажиллагаа өндөр хурд дээрээ байх үед илүү ажиллана. Усны түвшин бага болмогц машин хэвийн ажиллах ч үзүүлэлтийн гэрэл анивчиж эхлэх болно. Хэрэв усны савыг гаргавал үзүүлэлтийн гэрэл асаалттай, төхөөрөмж ажиллахаа болино.

6. АЖИЛЛАГААНЫ ТОДОРХОЙЛОЛТУУД

1. Асаах



Power

Төхөөрөмжийг тогонд залгасны дараа төхөөрөмжийг ажиллуулах POWER товч ажиллана. Энэ товчийг хоёр удаа дарахад төхөөрөмж түр горимонд шилжинэ. (Түр горимонд үед улаан, ажиллаж байх үед ногоон гэрэлтэй болно.)

2. Ажиллах горимыг сонгох



AUTO

AUTO товчийг даран төхөөрөмж ажиллаж эхлэхэд, сөрөг цэнэгтэй ионжуулагч, бактери устгагч гэрэл ажиллаж эхлэх бөгөөд мэдрэгчийн үзүүлэлтээс хамаарч хурд нь тохируулагдана. (Дүрс төхөөрөмж автомат үед асаалттай байх ба бусад үед гэрэлгүй байна.) Автомат үед хэрэглэгч сэнсний хурдыг соливол төхөөрөмж энэ горимоос автоматаар салгагдана.

Хурдны ба PM2,5 өгөгдлийн хоорондын хамаарал					
Хурд	PM2,5 өгөгдөл	Гэрлийн өнгө	Хурд	PM2,5 өгөгдөл	Гэрлийн өнгө
1	0-50	Ногоон	5	121-140	Шар
2	51-80		6	141-160	
3	81-100	Цэнхэр	7	161-300	Улаан
4	101-120		8	301-500	



TIMER

Timer товчин дээр дарах тутамд цаган дээр нэг цаг нэмэгдэнэ. Энэ нь хуримтлагдан 12 цаг болох үед, нэг илүү дарахад унтрана. (Дүрс төхөөрөмжийг цагийн горимоор ажиллах үед асаалттай байх бөгөөд бусад үед асахгүй).



INOIZER

Ionizer товчийг дарахад сөрөг ионжуулагч ажиллаж эхлэх бөгөөд дахин нэг удаа дарахад унтрана. (Үүнийг асаасан үед дүрс асаалттай байх бөгөөд бусад үед асахгүй.)



STERILIZE

Sterilize товчийг дарахад нян бактери устгагч гэрэл ажиллаж эхлэх бөгөөд дахин нэг удаа дарахад унтрана. (Үүнийг асаасан үед дүрс асаалттай байх бөгөөд бусад үед асахгүй.)




Reset Энэхүү төхөөрөмж нь 320 цаг ба 1500 цаг ажиллах тутамд шүүлтүүрийг солихыг сануулах үйлдэлтэй. 320 цаг тутмын дараа шүүлтүүр 1-ийг цэвэрлэхийг сануулж анивчина. Цэвэрлэсний дараа Reset товчийг 5 секундын турш дарахад гэрэл анивчихаа болино. 1500 цаг тутмын дараа шүүлтүүр 1 ба 3-ыг солихыг сануулж гэрэл асна. Энэ удаа товчийг 5 секундын турш дарж хугацааг дахин шинээр хийж болно.



Sleep товчин дээр дарахад төхөөрөмж унтлагын горимд ажиллаж эхэлнэ. Энэ горим дээр бүх гэрлүүд унтрах бөгөөд төхөөрөмж хамгийн эхний хурдаар ажиллана. Аль ч хамаагүй товчийг асаахдаа дарах ба Sleep товчийг дарж энэ горимоос гарах буюу wind speed ба smart товчнуудыг дарж энэ горимоос гарч болно.



Child lock Төхөөрөмжийг асаалттай үед энэ товчийг бүх товчийг түгжих зорилгоор дарна. Тэр үед ямар ч товчин дээр дарсан ажиллахгүй бөгөөд, өмнө нь ямар горимоор ажиллаж байсан, тэр горимоороо ажилласан хэвээр байна. Энэ товчин дээр 5 секундын турш дарахад төхөөрөмж энэ горимоос гарна. (Child lock горимоор ажиллах үед дүрс асаалттай байх бөгөөд бусад үед асахгүй.)



Wind speed Төхөөрөмжийг асаалттай үед "+" ба "-" товчийг дарж хурднуудыг сольж, ажиллах хурдыг тохируулж болно. Хурдыг сольсон тохиолдолд мотор мэдрэгчийн үзүүлэлтээс үл хамааран сонгосон түвшин дээр ажиллана. (Wind speed товчийг дарснаар төхөөрөмж автомат горимоос гарна.)



Light sensitive Автомат ажиллагаатай үедээ төхөөрөмж 5х-ээс бага орчны гэрэлтэй болсноос 2 минутын дараа унтлагын горимд шилжинэ. Орчны гэрэл 5х-ээс их болсны 3 минутын дараа унтлагын горимоос гарч автомат горимоор ажиллаж эхэлнэ.

3. Унтраах



Төхөөрөмжийг ажиллаж байх үед Power товчийг дарахад түр зогсолтын горимд шилжинэ.

4. Удирдлага



Энэ бүтээгдэхүүн нь жижиг дугуй батерейгаар ажилладаг алсын удирдлагатай. (Хэрэв алсын удирдлагыг удаан хугацааны турш ашиглахгүй бол батерейг салгана уу.) Анхаар: Удирдлаганы товчнууд нь их биен дээрх ижил товчнуудтай ижил ажиллагаа, үүрэгтэйгээр ажиллана. Үүрэг, ажиллагааны хувьд ерөнхийдөө ижилхэн. Хамгийн эхэлж ажиллуулахдаа батерейны тагийг авч батерейг уутнаас нь гарган буцааж хийн таглаарай. Ингээгүй тохиолдолд цэнэггүйгээр удирдлага ажиллахгүй.

7. ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ

- Auto mode. Төхөөрөмжийг ажиллаж байх үед Power болон AUTO товчийг дараалан дарахад төхөөрөмж ухаалаг мэдрэгчийн хяналтан дор ажиллаж эхлэнэ. Моторын ажиллах хэмнэл нь мэдрэгчийн цуглуулсан PM 2.5 өгөгдөлд үндэслэн автоматаар тохируулагдана. Энэ горим нь ихэнх тохиолдолд тохиромжтой.
- Compulsory mode . Төхөөрөмжийг ажиллаж байх үед Power товчийг дар. Wind speed товчийг дарж моторын хэмнэлийг сонгосны дараа сөрөг ионжуулагч болон Хэт чгаан туаны товчийг асаах буюу унтраана. Энэ горим нь чийгшүүлэгчийг заавал ажиллуулах нөхцөлд тохиромжтой. Энэхүү горим дээр төхөөрөмж хэмнэлийг автоматаар өөрлөх боломжгүй болно.
- Night mode. Дээрх хоёр горимд сануулсанчлан sleeping товч дарагдсан бол таныг амарч байх хугацаанд нөлөөлөх чимээтэй байхааргүйгээр хамгийн эхний хурдтайгаар ажиллана. Орчин харанхуй болохыг фото мэдрэгчээр мэдрэн унтлагын горим луу автоматаар шилжинэ.
- Timing mode. Дээрх гурван горимд, timing товчийг даран хугацаа тохируулагдсан үед, төхөөрөмжинд цаг гүйж эхэлсэн байна. Цаг дуусангуут төхөөрөмж ажиллахаа болино. (Цагийг зогсоохыг хүсвэл дэлгэцэн дээрх цагийг 12 болтол нь дарсны дараа дахин нэг удаа дарахад энэ горимоос гарна.)
- Child-proof lock mode. Дээрх дөрвөн горимд, төхөөрөмж дээр child-proof lock товчийг дарсны дараа хүүхдийн хамгаалалтын горимд шилжинэ. Энэ горимд байхад удирдлага болон их биен дээр хийгдсэн ямар ч үйлдэл хүчингүй болно. (Энэ горимоос child-proog lock товчийг 3 секундын турш дарж буюу удирдлаган дээр unlock товчийг дарж гарна.)


8. АНХААРАХ ЗҮЙЛС

Суурилуулах үедээ


1. Нарны шууд тусгал, эйр кондиционерын хавхлага руу харуулж болон халуун газруудад тавьж болохгүй. Эдгээр нь гажих, эвдрэх, гандах, буруу ажиллахад хүргэж болно.



Телевизор болон радиогийн ойролцоо бүү тавь. Энэ нь дүрсийг гуйвуулж, чимээ гаргуулах магадлалтай. Цэвэршүүлэгчийн удирдлагыг ашиглахад телевизор болон радиогийнхтой давхцаж болзошгүй. Эдгээрээс төхөөрөмжөө 1 ба түүнээс их метрийн зайд байрлуулна уу. Эдгээртэй нэг залгуурыг хувааж хэрэглэвэл мөн дүрсийг гуйвуулж, чимээ гаргуулах магадлалта. Ийм тохиолдолд, цэвэршүүлэгчийг өөр залгууранд залгах нь зүйтэй.




2. Энэ бүтээгдэхүүнийг тоос болон тоосонцрыг татахын тулд шалан дээр байрлуулах нь ёстой. Иймэрхүү зүйлс шалан дээр буудаг тул бүтээгдэхүүнийг шалан даар тэгшхэн гадаргуу дээр байрлуулна уу.



3. Үр дүнтэй агаарын урсгалын байлгах үүднээс ойролцоогоор хана болон бусад зүйлсээс 30 см-ээс дээш зайтай байрлуулна уу. Илүү үр дүнтэй ажиллагааг хангахын тулд хойд талыг хананаас багадаа 20 см зайтай байлгана.



4. Энэхүү төхөөрөмжөн дээр ажиллагаанд нь согог учрахаас сэргийлж ямар нэг зүйл тавихыг хориглоно. Соронзон болон бусад метал зүйл тавихгүй байхыг анхаарна уу.



5. Төхөөрөмжийн орох болон гарах агаарын урсгалыг хааж болохгүй. Жишээлбэл, орох урсгалын хажууд болон гарах урсгалын дээр ямар нэг зүйл тавьж болохгүй.


9. ХОРИГЛОХ ЗҮЙЛС

1. Төхөөрөмжийг ажиллаж байх үед дээш нь өргөх ба хөдөлгөж болохгүй. Хөдөлгөх болон далд хийхдээ цахилгааны утсыг татаж болохгүй. Энэ нь богино долгион буюу цахилгааны утсанд дотоод гэмтэл үүсгэж болзошгүй.

2. Цахилгааны утас болон залгуурыг гэмтээж болохгүй. Цахилгааны утсыг хэт их эрчилж, татаж, нугалж болохгүй. Цахилгааны утас гэмтсэн тохиолдолд өөрийн аюулгүй байдлын үүднээс үйлдвэрлэгч, засвар үйлчилгээний хэлтэс, мэргэжилтэн лүү утасдаж солиулна уу.



3. Заасан цахилгааны хүчдэлээс давсан үүсгүүр, универсаль залгуур болон бусад холбох төхөөрөмжийг ашиглахыг хориглоно. Зөвхөн 220В-5А АС тог ашиглана уу. Заасан цахилгааны хүчдэлээс давсан универсаль залгуур болон бусад холбох төхөөрөмжийг ашигласнаар хэт халалт үүсч гал гарах магадлалтай.



4. Залгуурт нойтон гараар хүрч болохгүй. Тогонд цохиулж болзошгүй.



5. Агаарын урсгал орох гарах хэсгүүдэд хуруугаа хүргэх болон метал зүйлс хийхийг хориглоно. Тогонд цохиулах, гэмтэл учирч болзошгүй.



6. Тогонд цохиулах, галын аюулаас болгоомжилж ус, галд автамхай цэвэрлэгч шингэн болон бусад шингэнийг төхөөрөмжний дотор оруулахаас зайлсхийнэ үү.



7. Энэхүү төхөөрөмж энгийн агаажржуулалтын төхөөрөмж, тоос сорогч, хиншүү сорогчийн үүргийг гүйцэтгэхгүй.



8. Төхөөрөмжийг шингэн хий ашигладаг төхөөрөмж, халаагч төхөөрөмж, зуухны ойролцоо ашиглаж болохгүй.



9. Төхөөрөмжийг шүршүүрийн өрөө, 00 өрөө, гал тогоо гэх зэргийн чийглэг болон халуун орчинд ашиглаж болохгүй.



10. Урьдчилан таамаглаагүй ослоос сэргийлж удирдлагыг хүүхэд хүрэхээргүй газар тавина уу.



11. Ажлын хавтангийн хоёр талын нум нь бариул биш бөгөөд татаж болохгүй. Бариулууд нь цэвэршүүлэгчийн их биений



12. Энэхүү төхөөрөмжийн дотор шингэн чийгшүүлэгч төхөөрөмж байгаа учир доош нь харуулж болохгүй.

13. Төхөөрөмжийг дараах газруудад тавьж болохгүй. Үүнд:

- Хөдөлгөөнтэй газар: налж унах, унах магадлалтай. Энэ нь гэмтэл, тогонд цохиулах болон галын аюултай.
- Шүршүүрийн өрөө мэтийн халуун болон чийглэг газар: энэ нь хүчдэл алдахад тогонд цохиулах, гал гарах зэрэг аюул үүсгэнэ.
- Уур гаргах гал тогоо мэтийн газар

14. Цэвэршүүлэгчийг хүж хэлбэрийн шавьж устгагч ашигласан өрөөнд хэрэглэж болохгүй:

- Химийн бодисын үлдэгдэл төхөөрөмж дотор хуримтлагдаж байгаад гаран биеийн эрүүл мэндэд хор хүргэж болзошгүй.
- Шавьж шумуул устгагчийг хэрэглэсний дараа өрөөг бүтэн агааржуулж байж цэвэршүүлэгчийг ашиглаж эхэлнэ үү.

10. ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС

1. Дараах тохиолдлуудын аль нэг нь гарвал, төхөөрөмжийг нэн даруй унтраана уу:
 - Ажиллаж байх үед ердийн бус дуу чимээ, чичиргээн үүсэх
 - Бүтээгдэхүүн хэвийн бусаар халах, шатсан үнэр гаргах
2. Залгуурыг тогтмол цэвэрлэнэ үү:
Хэрэв залгуур дээр тоос, чийг байвал энэ нь гэмтэх магадлалтай. Үүнээс галын аюул үүсэх аюултай:
 - Цахилгааны залгуурыг салгаж, хуурай алчуураар арчих
 - Төхөөрөмжийг удаан хугацаагаар ашиглахгүй тохиолдолд цахилгааны залгуурыг салгах
3. Цахилгааны засвар үйлчилгээ хийж байх үедээ залгуурыг салгасан эсэхийг нятлана уу.
 - Бүтээгдэхүүн гэнэт асч тогонд цохиулах, гэмтэж болзошгүй.
4. Цахилгааны залгуурыг үүр лүү хөдөлгөөнгүйгээр бэхэлж хийнэ үү.
Хэрэв сайн хөдөлгөөнгүй хийгээгүй бол халалт үүсч цахилгаанд цохиулах цаашлаад галын аюулд хүргэж болзошгүй.
 - Гэмтэлтэй залгуур болон сул үүрийг хэрэглэж болохгүй.
5. Утсыг салгахдаа урд хөндийрүүлэгчийг барьж салгана уу:
 - Салгахдаа утсыг ашиглах нь утсыг гэмтээх, тогонд цохиулах, богино долгион үүсэх, гал гарах зэрэг аюул гаргах магадлалтай.
6. Дараах нөхцлүүд тохиолдвол төхөөрөмжийг шууд унтраан үйлчилгээний хэлтэстэй холбоо барина уу:
 - Шилжүүлэг ажиллахгүй байх
 - Залгуур болон утас хэвийнээс илүү халсан байх
 - Хэвийн бус дуу чимээ чичиргээ үүсэх
 - Бусад хэвийн бус ажиллагаа, гажилт үүсэх
7. Цахилгаанд цохиулах аюулаас сэргийлэхин тулд зөвхөн дадлагажсан мэргэжилтэн төхөөрөмжийг задлах ёстой.




11. ШҮҮЛТҮҮР/ ТООС МЭДРЭГЧ/ ИОНЖУУЛАГЧИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ БА АРЧИЛГАА

1. Урьдчилсан шүүлтүүр (ойролцоогоор сард хоёр удаа)



- Шүүлтүүрийн гадаргууг тоос сорогчоор соруулах буюу усаар угаана. Бүрэн хатсаны дараа хэрэглэнэ.

2. Эсийн идэвхжүүлэлттэй нүүрсэн шүүлтүүр (ойролцоогоор хоёр сар тутамд нэг удаа)



- Шүүлтүүрийн урд хэсгийн тоосыг тоос сорогчоор соруулж цэвэрлэнэ.
- Агааржуулалт сайтай газар шүүлтүүрийг тавьж хорт хий, бактерийг устгана. Нарны хэт их тусгалтай газар тавьж болохгүй.
- Шүүлтүүр их эмзэг тул тоосыг соруулж байхдаа чанга дарж болохгүй.
- Энэ шүүлтүүрийг цэвэрлэхдээ ус хүргэж болохгүй.

3. Нян бактерийн эсрэг ХЕПА шүүлтүүр (ойролцоогоор хоёр сар тутамд нэг удаа)




- Агааржуулалт сайтай газар шүүлтүүрийг тавьж хорт хий, бактерийг устгана. Нарны хэт их тусгалтай газар тавьж болохгүй.
- Энэ шүүлтүүрийг цэвэрлэхдээ ус хүргэж болохгүй.

4. Ионжуулагчийн цэвэрлэгээ ба арчилгаа



- Төхөөрөмжинд чихрах дуу гарвал 1 болон 2 дугаарын будгийн бийрийг цэвэрлэх багаж болгон ашиглаж ион гарах толгой хэсгийн дээрх агааржуулалтын цонх руу хийнэ. Энэхүү агаар гарах хэсгийн тоосыг тогтмол цэвэрлэнэ үү.

5. Тоос мэдрэгч (ойролцоогоор хоёр сар тутамд нэг удаа)



- Тоосыг арилгахдаа линзийг цэвэр хөвөнгөөр хийгдсэн хуурай чихний цэвэрлэгчийн үзүүрээр арчина. (Чийг болон утааны үлдэгдэл үүнийг бүрэн ажиллагаагүй болгосон байх магадлалтай.) Эхлээд тоос мэдрэгчийн тагийг салгажаваад хуурай хөвөн даавуун чих цэвэрлэгчээр линзийг арчина.
- Энэ цэвэрлэгчийг линзнээс өөр газар хүргэж болохгүй.
- Цахилгааны утсыг салгасан байх ёстой.
- Сайн харахгүй байвал гэрэл хэрэглэнэ үү.

Нөхөрсөг сануулга:

- Цэвэрлэх, арчлахдаа тогийг салгана уу
- Төхөөрөмжийг шүүлтүүргүйгээр ажиллуулж болохгүй. Тоосыг арилгаж чадахгүй болно. Төхөөрөмж рүү орсон тоос үүнийг ажиллагаагүй болгож болно. Төхөөрөмжийг удаан хугацаагаар ашиглахгүй тохиолдолд цахилгааны залгуурыг салгана уу. Энэ нь түр зогсолтын горимд байхдаа ч тог хэрэглэж байдаг.
- Хаана, хэрхэн хэрэглэж байгаагаас шалтгаалан шүүлтүүрийг илүү хурдан солих ёстой болж болно. (олон хүн тамхи татдаг гэр бүл, илүү их агаарын бохирдолтой газар гэх мэт). Шүүлтийн хэмжээ онц мэдрэгдэхгүй тохиолдолд шүүлтүүрийг солино уу.

12. САВ БАГЛАА БООДЛЫН ЖАГСААЛТ

Төхөөрөмж	1 ширхэг
Алсын удирдлага	1 ширхэг
Шүүлтүүр	3 ширхэг
Чийгшүүлэгчийн тор	1 ширхэг
Ашиглалтын заавар	1 ширхэг

13. ГЭМТЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Асуудал	Тодорхойлох/Хэрхэн засах
Асааж чадахгүй байх буюу товчийг дарахад ажиллахгүй байх	1. Цахилгааны залгуурыг залгасан эсэх? Цахилгааны үүрэнд залгах 2. Цэвэршүүлэгчийг тагласан эсэх? Нүүрэн талыг таглах 3. Төхөөрөмжийг газарт босоогоор нь байрлуулсан уу? Төхөөрөмжийг тэгш гадаргуу дээр байрлуулх. 4. Төхөөрөмж child lock горим дээрээ байгаа эсэх? Child lock дэлгэцэн дээр харагдаж байвал, lock/reset товчийг 5 секунд дарж горимыг унтраах
Агаар бохир боловч агаарын чанарын үзүүлэлт ногоон байна. Тасралтгүй ажиллаж байвч агаарын чанарын үзүүлэлт улаан хэвээр байна.	1. Цэвэршүүлэгч бохир агаар (тоос)-ыг шингээж авч чадахааргүй газар байрласан байна уу? Өөр газар луу шилжүүлж үз. 2. Тоосны мэдрэгч бохирдсон эсэх? Тоосны мэдрэгчийг цэвэрлэ.
Ажиллуулж байх үед цохих, шунгинах чимээ гарах	Ионжуулагч дээр их тоостой байна уу? Ионжуулагчийн тоосыг цэвэрлэх.
Агаар гарах хэсгийн онцгүй үнэр	1. Шүүлтүүр бохирдсон эсэх? Шүүлтүүрийг цэвэрлэх. 2. Шүүлтүүрийг солилгүй удсан эсэх? Шүүлтүүрийг солих.
Цэвэршүүлэгч удаан хугацаагаар ажиллаж байгаа боловч агаарын чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарахгүй байна	1. Шүүлтүүрийн гялгар уутыг авсан эсэх? Хэрэглэхээс өмнө шүүлтүүрийн гялгар боодлыг авах 2. Шүүлтүүрийн байршил солигдсон эсэх? Зөв байршилд оруулах
Дэлгэцэнд F1ба F2 гарах	Тогноос даруй салгаад засварын хэлтэстэй холбоо барих
Төхөөрөмж унтлагын горимдоо шилжээд байх	Автомат горимыг хүчингүй болгох

ЭКО АГААР, ЭРҮҮЛ АМЬДРАЛ